



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

412.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1610
413.	Аврах ажиллагааны тухай конвенцид нэгдэн орох тухай	1610
414.	Далайн хөдөлмөрийн тухай конвенцид нэгдэн орох тухай	1611
415.	“Олон талын хөрөнгө оруулалтыг баталгаажуулах байгууллага”-ын конвенцид орсон нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай	1611
416.	Засгийн газрын бүтцийн тухай	1611
417.	Засгийн газрын бүрэлдэхүүний тухай	1612
418.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1613
419.	Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1622
420.	Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1622
421.	Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1623
422.	Хэлэлцээр соёрхон батлах тухай	1623

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

423.	Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 06 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 72	1624
424.	Б.Хурцыг Авлигатай тэмцэх газрын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 73	1625



425.	Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 74	1625
426.	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай	Дугаар 75	1626
<b>МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ</b>			
2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр		Улаанбаатар хот	
<b>ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ</b>			
<p><b>1 дүгээр зүйл.</b>Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p>			
<p>“3.1.3.“хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл шүүхэд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх болон хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг;”</p>			
<p><b>2 дугаар зүйл.</b>Энэ хуулийг 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>			
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА</b>		<b>З.ЭНХБОЛД</b>	
<b>МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ</b>			
2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр		Улаанбаатар хот	
<b>АВРАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ</b>			
<p><b>1 дүгээр зүйл.</b>Аврах ажиллагааны тухай 1989 оны Лондонгийн конвенцид Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдэн орсугай.</p>			
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА</b>		<b>З.ЭНХБОЛД</b>	



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 11 дүгээр  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ДАЛАЙН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ  
КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Далайн хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2006 оны конвенцид Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдэн орсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 11 дүгээр  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот

**“ОЛОН ТАЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ  
БАТАЛГААЖУУЛАХ БАЙГУУЛЛАГА”-ЫН КОНВЕНЦИД  
ОРСОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН  
БАТЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** “Олон талын хөрөнгө оруулалтыг баталгаажуулах байгууллага”-ын конвенцид орсон нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана:

Ерөнхий чиг үүргийн

- 1/Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам;
- 2/Гадаад хэргийн яам;



3/Сангийн яам;  
4/Хууль зүйн яам;

Чиглэлийн

5/Аж үйлдвэрийн яам;  
6/Барилга, хот байгуулалтын яам;  
7/Батлан хамгаалах яам;  
8/Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;  
9/Зам, тээврийн яам;  
10/Уул уурхайн яам;  
11/Хөдөлмөрийн яам;  
12/Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам;  
13/Хүнс, хөдөө аж ахуйн яам;  
14/Эрүүл мэнд, спортын яам;  
15/Эрчим хүчний яам.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнийг доор дурдсанаар тогтоосугай:

1/Монгол Улсын Ерөнхий сайд;  
2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд;

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад хэргийн сайд;  
6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайд;  
7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүйн сайд;



8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэрийн сайд;

9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайд;

10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайд;

11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд;

12/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд;

13/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Уул уурхайн сайд;

14/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөрийн сайд;

15/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд;

16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуйн сайд;

17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэнд, спортын сайд;

18/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайд;

19/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана:



Ерөнхий чиг үүргийн

- 1/Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам;
- 2/Гадаад хэргийн яам;
- 3/Сангийн яам;
- 4/Хууль зүйн яам;

Чиглэлийн

- 5/Аж үйлдвэрийн яам;
- 6/Барилга, хот байгуулалтын яам;
- 7/Батлан хамгаалах яам;
- 8/Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;
- 9/Зам, тээврийн яам;
- 10/Уул уурхайн яам;
- 11/Хөдөлмөрийн яам;
- 12/Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам;
- 13/Хүнс, хөдөө аж ахуйн яам;
- 14/Эрүүл мэнд, спортын яам;
- 15/Эрчим хүчний яам.”

2/20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудал хамаарна:

-улсын хөгжлийн цогц бодлого;  
-эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох асуудал;

-хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого;  
-гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт,

бүртгэл;

-концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого;  
-төрийн өмчийн бодлого;

асуудал;

-тагнуул, сөрөг тагнуул, терроризмаас урьдчилан сэргийлэх

бодлого;

-цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах

асуудал.”

-мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны



3/20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх асуудлыг эрхэлнэ:

1/Монгол Улсын Шадар сайд:

-гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудал;  
-хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой шуурхай асуудал;

-стандартчилал, хэмжил зүйн асуудал;  
-шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах асуудал;  
-хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал;  
-төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа;

-оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;  
-тодорхой салбарын мэргэжлийн хяналтын асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

2/Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга:

-Засгийн газрын шийдвэрийн биелэлт;  
-Засгийн газрын дотоод мэдээлэл;  
-Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах асуудал;  
-төрийн албаны хүний нөөцийн асуудал;  
-орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого;

-орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, удирдлага;

-Засаг даргын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах асуудал;

-иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үзүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.



3/Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд:

-ногоон хөгжлийн бодлого;  
-байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого;

-газар зохион байгуулалт болон усны нэгдсэн бодлого;  
-цөлжилттэй тэмцэх болон ойжуулалтын асуудал;  
-усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах асуудал;

-ургамал, ан амьтны нөөцийг хамгаалах асуудал, мэдээллийн сан;

-байгаль орчны шинжилгээ, ус цаг уур болон байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах асуудал;

-биоаюулгүй байдлын бодлого;  
-аялал жуулчлалын бодлого;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

4/Гадаад хэргийн сайд:

-гадаад улс, олон улсын байгууллагатай улс төрийн талаарх хамтын ажиллагаа;

-гадаадад байгаа Монгол Улсын иргэд, бизнесийн эрх ашгийг хамгаалах асуудал;

-гадаад улс, олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээрийн асуудал болон байгуулсан гэрээ, хэлэлцээрийн явцад тавих хяналт;

-гадаад улс, олон улсын байгууллагатай хүмүүнлэгийн чиглэлээрх хамтын ажиллагаа;

-дипломат, албан зэргийн виз, консулын асуудал;  
-гадаад сурталчилгаа;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.





5/Сангийн сайд:

-макро эдийн засгийн бодлогын төлөвлөлт, зохицуулалт;  
-улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудал;

-санхүүгийн зах зээл, төсвийн орлого, зарлага, өрийн удирдлагын асуудал;

-нэгдсэн төсвийн талаарх судалгаа, төлөвлөлт;  
-төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, санхүүжилтийн үйл ажиллагаа;

-улсын болон орон нутгийн төсвийн зарцуулалтын хяналт;  
-зээл, тусламжийн нэгдсэн бодлого;  
-нягтлан бодох бүртгэлийн бодлого;  
-гаалийн бодлого;  
-татварын бодлого;  
-даатгалын бодлого;

-төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах бодлого;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

6/Хууль зүйн сайд:

-эрх зүйн шинэтгэлийн бодлого;  
-хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа;

-эрх зүйн туслалцаа;  
-улсын хил хамгааллын асуудал;  
-цагдаа, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал;

-шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;  
-Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, хуульчдын олон нийтийн байгууллагатай харилцах асуудал;

-төрөөс сүм хийдтэй харилцах асуудал;  
-иргэний харьяалал, цагаачлалын асуудал;  
-энгийн зэргийн виз, Монгол Улсад орох, гарах, оршин суух гадаадын иргэний асуудал;



-төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянах асуудал;

-иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;  
-хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүртгэл;  
-архивын талаар төрөөс баримтлах бодлого;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

7/Аж үйлдвэрийн сайд:

-хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал;  
-хөнгөн үйлдвэрлэлийн бодлогын асуудал;  
-аж үйлдвэрийн паркийн асуудал;  
-жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн асуудал;  
-чөлөөт бүсийн хөгжлийн асуудал;  
-экспорт, импортын асуудал;  
-дотоод, гадаад худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалт;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

8/Барилга, хот байгуулалтын сайд:

-барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого;  
-хот төлөвлөлт болон хот байгуулалтын бодлого, архитектурын асуудал;

-орон сууцны бодлого;  
-нийтийн аж ахуйн асуудал;  
-газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

9/Батлан хамгаалахын сайд:

-улсыг батлан хамгаалах бодлого болон цэргийн бодлого;  
-зэвсэгт хүчнийг чадваржуулах бодлого;  
-энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэл хангуулах асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.



10/Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд:

-боловсролын тогтолцоог хөгжүүлэх асуудал;  
-шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын асуудал;

-шинжлэх ухаан, технологийн мэдээлэл;  
-өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал;

-ном хэвлэл, цахим бичвэрийн бодлого;  
-соёл, урлагийг хөгжүүлэх асуудал;  
-түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

11/Зам, тээврийн сайд:

-авто замын асуудал;  
-авто тээврийн асуудал;  
-төмөр замын тээврийн асуудал;  
-иргэний нисэхийн асуудал;  
-далай ашиглах болон усан замын тээврийн асуудал;  
-тээврийн тогтолцоог хөгжүүлэх бодлого, зохицуулалт;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

12/Уул уурхайн сайд:

-геологи, эрдэс баялгийн бодлого;  
-геологийн эрэл, хайгуул, судалгааны зохицуулалт;  
-газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлого;

-олборлох үйлдвэрийн техник, технологийн асуудал;  
-ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлого;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

13/Хөдөлмөрийн сайд:

-хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах бодлого;



-хөдөлмөрийн нөхцөл, ажиллагчдын цалин, амьдралын өртгийн талаарх асуудал;

-хөдөлмөрийн харилцаа, Засгийн газар, эзэд, Үйлдвэрчний эвлэлийн гурван талт түншлэл, хөдөлмөрийн хамтын маргааны зохицуулалтын асуудал;

-хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт;  
-хөдөлмөрийн биржийн асуудал;  
-Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэний асуудал;

-гадаадад ажиллах хүч гаргах асуудал;  
-мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн тогтолцоог хөгжүүлэх асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

#### 14/Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд:

-хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал;  
-нийгмийн халамжийн бодлого;  
-нийгмийн даатгалын бодлого;  
-хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадын болон гэр бүлийн хөгжлийн асуудал;

-жендэрийн хөгжлийн асуудал;  
-хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

#### 15/Хүнс, хөдөө аж ахуйн сайд:

-хүн амын хүнсний хангамжийн бодлого;  
-хүнсний аюулгүй байдлын асуудал;  
-мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;  
-газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;  
-мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого;

-мал, амьтан, ургамлын хорио цээрийн асуудал;  
-бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах асуудал;  
-мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эдийн экспорт, импортын асуудал;



-хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого;

-малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

16/Эрүүл мэнд, спортын сайд:

-хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх бодлого;

-эм, эмнэлгийн хэрэгсэл, техникийн үйлдвэрлэл, хангамжийн талаарх бодлого;

-эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар судлалын хүрээний бодлого;

-хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн болон мэргэжлийн арга хэмжээ;

-нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого;  
-мэргэжлийн спортын хөгжлийн асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

17/Эрчим хүчний сайд:

-эрчим хүчний нэгдсэн бодлого;  
-эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн асуудал;

-сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудал;  
-эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах бодлого;

-түлшний хангамж, нөөцийн бодлого, зохицуулалт;  
-эрчим хүчний нүүрс;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал.

18/Монгол Улсын сайд:

-үндэсний хэмжээний бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудал.”



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ ХУУЛЬ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2012 оны 08 дугаар сарын 16-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ  
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2012 оны 08 дугаар сарын 16-ны өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### КОНЦЕССЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Концессын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийн “хөрөнгө оруулалтын болон концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Концессын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.5, 9.8 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтын “төв” гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 12 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын 2013 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**2014 оны 11 дүгээр  
сарын 21-ний өдөр

Дугаар 72

Улаанбаатар  
хот**Үндсэн хуулийн цэцийн 2014 оны  
06 дугаар дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийн 1 дэх заалтын “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын ““хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл шүүхэд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж шүүн таслах ажиллагаанд оролцох болон бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэхийг;” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... тэгш байдал, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчсөн байна.” гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийн 1 дэх заалтын “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын ““хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл шүүхэд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж шүүн таслах ажиллагаанд оролцох болон бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэхийг;” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... эрхтэй. ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.” гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийн 1 дэх заалтын “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын ““хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл шүүхэд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж шүүн таслах ажиллагаанд оролцох болон бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэхийг;” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “... хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан ... иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.” гэснийг хүлээн зөвшөөрсүгэй.





4.Энэ тогтоолыг 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 11 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар  
хот

**Б.Хурцыг Авлигатай тэмцэх газрын  
дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Авлигын эсрэг хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Батын Хурцыг Авлигатай тэмцэх газрын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2014 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 74

Улаанбаатар  
хот

**Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт  
оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хамт Улсын Их Хуралд



өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 75

Улаанбаатар  
хот

**Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо,  
бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2014 оны  
75 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТООЛЦОО,  
БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ**

<b>Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал</b>	<b>Засгийн газрын тохируулагч агентлаг</b>	<b>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг</b>
Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд	1.Тагнуулын ерөнхий газар 2.Төрийн өмчийн хороо 3.Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	1.Хөрөнгө оруулалтын газар



Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	4.Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 5.Онцгой байдлын ерөнхий газар 6.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 7.Стандартчилал, хэмжил зүйн газар	2.Худалдан авах ажиллагааны газар 3.Оюуны өмчийн газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд		
Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		4.Цаг уур, орчны шинжилгээний газар
Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		5.Гаалийн ерөнхий газар 6.Татварын ерөнхий газар
Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	8.Цагдаагийн ерөнхий газар 9.Хил хамгаалах ерөнхий газар	7.Улсын бүртгэлийн ерөнхий газар 8.Архивын ерөнхий газар 9.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 10.Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар 11.Тахарын ерөнхий газар
Аж үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		12.Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар



Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	10.Зэвсэгт хүчний жанжин штаб	
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		13.Иргэний нисэхийн ерөнхий газар
Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		14.Ашигт малтмалын газар 15.Газрын тосны газар
Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		16.Мал эмнэлэг, үржлийн газар
Хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		17.Нийгмийн даатгалын ерөнхий газар 18.Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар 19.Хүүхдийн төлөө үндэсний газар
Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Монгол Улсын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medecelel@parliament.mn](mailto:turiin_medecelel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

**Индекс: 14003**